



дг

ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 05 сарын 29 едэр

Дугаар 110

Шивээговь сум

Газар зүйн нэрийн тодруулалтын ажилд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Сумын нутаг дэвсгэрийн “Газар зүйн нэрийн тодруулалт”-ын ажлын суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэгч байгууллага “Кли макс реферэнс ХХК /5338271/-тай байгуулсан гэрээний дагуу ажлын урьдчилгаа санхүүжилт болох үнийн дүнгийн 30% буюу 3,750,000 (гурван сая долоон зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх ажилд зарцуулагдах 3,750,000 (гурван сая долоон зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын “Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал”-аас гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох ажлыг зохион байгуулж, анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

